



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/19

Жаргалтхаан

**Хүндэтгэл үзүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII жарны "Элдэв Эрдэнэт" хэмээх Модон Могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан тус сумын харъяат аймгийн Арслан Шаравдоржийн Отгонтөгст хүндэтгэл үзүүлэхэд зориулж 300,000 (гурван зуун мянган) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Загдхүү нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ